



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 04

Шарга

Г

Журам батлах тухай

Т

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Малын удмын сан, Эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Нохой эзэмших, золбин нохой устгахад мөрдөх журамыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг олон нийтэд сурталчлан хэрэгжүүлж, хяналт тавин үр дүнг тайлagnаж ажиллахыг засаг дарга /Д.Түмэнбаяр/-д даалгасугай.
3. Энэ журмыг дагаж мөрдөн, хэрэгжүүлж ажиллахыг аж ахуйн нэгж, албан байгууллага, нийт иргэдэд уриалсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л. Сэргсмаа/-д үүрэг болгосугай.



00061

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2014 оны 01-р сарын 27-ны өдрийн
04. тоот тогтоолын хавсралт

**НОХОЙ ЭЗЭМШИХ, ЗОЛБИН НОХОЙ
УСТГАХАД МӨРДӨХ ЖУРАМ**

Нэг: Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь төв суурин газар оршин суугч иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчины зруул ахуй, халдварт болон паразит өвчнөөс хүн, малыг урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж золбин нохойн тоог бууруулахад оршино.

Хоёр: Ерөнхий зүйл

- 2.1 Угжурмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлах ба тухайнөдрөөсэхлэнхүчин төгөлдөр хэрэгжижээ.
- 2.2 Журмыгбаг, сумын Засагдарга, цагдаагийн тасаг, байгаль хамгаалагч, улсын байцаагчнаар хэрэгжүүлж нохой эзэмшигч /тэжээгч/ иргэн, аж ахуйн нэгжүүд дагаж мөрднө.

Гурав: Нохой эзэмшигчийн үүрэг

- 3.1 Хоточ, анч, мөрч, гоёлын болон өмч хөрөнгө хамгаалуулах чиглэлээр нохой тэжээж буй бүх иргэд нохойгоо тооллогод хамруулж бүртгүүлэх.
- 3.2 Бүртгэлд хамруулсан нохойдоо гэрчилгээ авч, гэрчилгээний дугаартай пайз, таних тэмдэг /улаан/ бүхий хүзүүвч зүүх.
- 3.3. Эзэмшиж буй нохойдоо ноогдох хураамжийг жил бүрийн нэгдүгээр улиралд /1-3 сар/ багтаан эрх бүхий албан тушаалтанд хураалгаж гэрчилгээнд тэмдэглэл хөтлүүлэх.
- 3.4 Тэжээвэр нохойг шөнийн цагаар буюу 22 цагаас өглөөний 06 цаг хүртэл эзэмшлийн хашаандaa сул байлгаж болох ба өдрийн цагаар уяа болон тусгай хашаанд байлгаж, гадаа гудамж талбайд зугаалуулах тохиолдолд хөтлөх буюу хяналтандaa байлгах.
- 3.5 Өөрийн хашааны дотор ба гадна талбай дахь нохойны ялгадсыг тогтмол цэвэрлэх.
- 3.6 Улирал бүр Мал эмнэлгийн байгууллагаар нохойдоо туулгалт, нохойн байр, хэвтэрт ариутгал халдвартгуйжүүлэлт хийлгэн, Мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдсан тухай тэмдэглэлийг ерхийн үйлчилгээний дэвтэрт хөтөлсөн байх.

- 3.7 Охин нохой тэжээж буй айлууд гарсан гэлгөө эзэнжүүлэх, устах арга хэмжээг авах.
- 3.8 Нохой тэжээж, эзэмшиж байгаа иргэд журманд заагдсан үүргээ үл биелүүлэхийг хориглох.

Дөрөв: Журам хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт.

4.1 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх, үүрэг.

4.1.1 Мөнгөний ханш бараа таваарын өсөлттэй уялдуулан тэжээвэр нохойны хураамжийг жил бүр тогтоож төсвийн төсөлд тусган батлах.

4.1.2 Журам хэрэгжүүлэгчдээс гарсан санал дүгнэлтийг үндэслэн журманд өөрчлөлт оруулах

4.1.3 Журмын хэргэжилтэнд хяналт тавих

4.2 Баг, сумын Засаг даргын эрх, үүрэг.

4.2.1 Тэжээвэр нохойг жил бүрийн мал тооллоготой хамтатган тоолж жилийн эцэст гэрчилгээг баталгаажуулах, шинээр гэрчилгээ олгох, пайзжуулах ажлыг зохион байгуулах.

4.2.2 Нохой эзэмшигчээс оны эхний улиралд багтаан ИТХ-аар тогтоосон нохойны хураамжийг төвлөрүүлж журманд заагдсан хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах.

4.2.3 Золбин нохой устгах, туулгалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

4.2.4 Журмын хэргэжилт, үр дүнг ИТХ, түүний тэргүүлэгчдэд тайлагнах

4.3 Цагдаагийн хэсэг, Байгаль хамгаалагч, Улсын байцаагч нарын эрх, үүрэг.

4.3.1 Журманд заагдсан нохой тэжээгч иргэдийн үүргийн биелэлтийг хангуулах, шаардлага тавих

4.3.2 Нохойн устгах, туулгалт, ариутгал халдвартгуйжүүлэх ажил гүйцэтгэж буй байгууллагад хяналт тавих

4.3.3 Гарсан зөрчил дутагдлыг илрүүлж журманд заагдсан хариуцлага хүлээлгэх, торгуулийн арга хэмжээ авах эрхтэй.

Тав: Журам зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

5.1 Золбин нохой устгах нэгдсэн ажлын үеэр уяа хамгаалалтгүй байснаас тэжээвэр нохойны устгагдсан бол журмыг хэрэгжүүлэгч тал хариуцлага хүлээхгүй.

5.2 Журманд заагдсан үүргээ биелүүлээгүй улмаас, иргэдийн бие болон бусад эд материал, мал хөрөнгөд хохирол учирнуулсан бол хохирлыг бурэн барагдуулах ба уг этгээдийн гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

5.3 Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 16.2.1 заалтыг үндэслэн журмыг зөрчсөн иргэнийг 10000-50000, албан тушаалтаныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000-500000 төгрөгөөр торгоно.

000

00064